



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/331

Хэрлэн сум

Аймгийн бичил уурхайн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засагзахиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "б", 29.3, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дах заалтууд, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 8.1.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.18.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Бичил уурхайн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах, албажуулах, бичил уурхайн нөхцөл байдал, түүнтэй холбоотой асуудлыг судлан санал өгөх, газрын хэвлийг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, бичил уурхай эрхлэгчдийг тогтвортой ажлын байраар хангах, жижиг дунд бизнес эрхлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлж, хоёрдогч ажлын байрын эх үүсвэрийг бий болгох, эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөмж гарган Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний холбогдох агентлагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах үүрэг бүхий бичил уурхайн аймгийн дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд зөвлөлийн дарга:	Ж.Ганбаатар	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Л.Бат-Октябрь	-Хууль эрх зүйн хэлтсийн дарга
	Э.Мөнх-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Б.Дархантөр	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Г.Тайванжаргал	-Батноров сумын Засаг дарга
	Ж.Энхтөр	-Дархан сумын Засаг дарга
	Ц.Идэрбат	-Хэрлэн сумын Засаг дарга
	Ч.Чинбат	-Бэрх тосгоны Захирагч
Б.Энх-Эрдэнэ	-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга	


Ц.Баярмаа	-Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
Д.Баярмаа	-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга
Ц.Билэгсайхан	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга
М.Мөнхнаран	-Татварын хэлтсийн Татварын орлогын тасгийн дарга
Д.Дашнамжилмаа	-Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн дарга
С.Амгаланбаатар	-Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Б.Бат-Эрдэнэ	-Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч
Г.Мөнх-Эрдэнэ	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын уул уурхай, газрын хэвлий, тусгай хамгаалалт хариуцсан мэргэжилтэн
Н.Нацагмаа	-Хэнтий аймгийн хариуцлагатай бичил уурхайн нэгдсэн холбоо ТББ-ын тэргүүн
С.Мөнхсарнай	-Хэнтий аймгийн хариуцлагатай бичил уурхайн нэгдсэн холбоо ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн
Ц.Цэндсүрэн	-Хэнтий аймгийн хариуцлагатай бичил уурхайн нэгдсэн холбоо ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн
Нарийн бичгийн дарга:	Б.Мөнхжаргал
	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хөдөө аж ахуй, Байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтэн

2. Бичил уурхайн аймгийн зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/ -т даалгасугай.

3. Бичил уурхайн үйл ажиллагааг орон нутагт албажуулах, бичил уурхайгаас оруулж буй хувь нэмрийг бодитоор үнэлэх, орон нутгийн эдийн засгийн хөгжилд татан оруулах, бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудалд төлөвлөгөө, удирдамж гарган хэрэгжүүлэх, Засаг дарга болон зөвлөлийн гишүүдийг мэдээлэл, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг дэд зөвлөлийн дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/193 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА